

СОЛОНГОС ХЭЛНИЙ ДАДЛАГАЖИГЧ (D 4 1)

ОЛГОХ ХҮРЭЭ:

Ерөнхий боловсролын сургуулийн төгсөгч их, дээд сургуулийн харьяа хэлний бэлтгэлд солонгос хэлсуралцах гэж буй иргэн.

БНСУ-д хэлний бэлтгэлийн визээр нэвтрэхийг хүсэж буй иргэн **Солонгосын Виз Мэдүүлэх Төвөөр** дамжуулан визээ мэдүүлнэ. Та 6 сарын хугацаанд хүчинтэй нэг удаагийн нэвтрэх эрхтэй виз мэдүүлж болох бөгөөд БНСУ-ын ЭСЯ-аас нэмэлт бичиг баримтууд шаардаж болно. Виз мэдүүлж буй МУ-ын иргэн хамгийн сүүлд төгссөн сургуулийн диплом ба дүнгийн жагсаалтын эх хувийг СВМТ-д өгөх бөгөөд эцсийн шийдвэр гарсан даруйд паспортын хамт буцаан олгогдоно.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт:Цээж зураг (3.5 x 4.5 см хэмжээтэй, сүүлийн 6 сарын дотор авахуулсан) , Визний хураамж 60 ам.доллар (Засгийн газрын тэтгэлэгт оюутан, Батлан хамгаалах яамны мэргэжилтэн оюутнууд, KOICA – шугамаар суралцах оюутнуудад хамаарахгүй)
2. Гадаад паспорт, хуулбарын хамт 1 хувь
3. Товч намтар (ЭСЯ-ны маягтын дагуу бөглөх, MS Word, Hangul программ ашиглах, заавал өөрийн гараар гарын үсгээ зурах)
4. Элсэлтийн зөвшөөрлийн гэрчилгээ, Сургуулийн ААН гэрчилгээний хуулбар
5. Хэлний бэлтгэлийн төлөвлөгөө (Хичээлийн хуваарь, хичээл заах багш нарын танилцуулга), Хэлний бэлтгэл хичээлийн өнөөгийн байдал (Сургуулийн өөрийн маягтаар)
6. Сургалтын зардал, санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Өөрийн эсвэл батлан даагчийн нэр дээрх Монгол дахь банкны дансны тодорхойлолт (Виз мэдүүлэх өдрөөс өмнө 14 хоногийн дотор авсан байх)
 - * Дансанд байршуулсан 10000 USD мөнгөн дүн нь виз мэдүүлэх өдрийг хүртэл нэг сараас дээш хугацаанд хөдөлгөөнгүй байх ба виз мэдүүлгийг шалгаж дуусах хүртэл заасан доод хэмжээнээс буухгүй байх. Хэрэв мөнгө байршуулсан хугацаа 30 хоногоос доош бол санхүүгийн чадвар нотолж чадаагүйгээр тооцох.
 - * Дансны тодорхойлолт дээр тодорхойлолтын огноо тодорхой тусгагдсан байх.

Батлан даагч 1 - Батлан даагч 2

 - Батлан даагчийн иргэний үнэмлэхийн хуулбар, Гэр бүлийн холбоо хамаарлыг нотлох бусад бичиг баримт – 3 үе дотроо
 - Батлан даагчийн өргөдөл, ажлын газрын тодорхойлолт
 - Батлан даагчийн сарын орлогыг нотлох бичиг баримт (Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон лавлагаа, татварын тодорхойлолт г.м)
7. Гэрлэлтийн лавлагаа
19 нас хүрээгүй иргэний хувьд төрсний бүртгэлийн лавлагаа авах бөгөөд төрсний бүртгэлийн лавлагаа дээр эцэг эхийн төрсөн он сар өдөр тэмдэглэгдээгүй тохиолдолд эцэг эхийн иргэний үнэмлэхний хуулбар авчрах.
*Гэрлэлтээ батлуулаагүй хүүхэдтэй иргэний хувьд хүүхдийн төрсний бүртгэлийн лавлагаа нэмэлтээр авах.
8. Цагдаагийн газрын тодорхойлолт (18 нас хүрсэн иргэн болон анх виз мэдүүлж бай иргэнд хамаарна)
9. Сүрьеэгийн шинжилгээ: (БНСУ-ын ЭСЯ-аас зөвшөөрөгдсөн эмнэлгээс авсан байх)
10. Хамгийн сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ, диплом, дүнгийн жагсаалтын эх хувь
 - Одоо сурч байгаа болон чөлөөтэй буюу завсарласан байгаа оюутнууд.: Ахлах сургууль төгссөн гэрчилгээ, их сургуульд сурч байгаа нь үнэн гэсэн тодорхойлолт, өмнөх жилийн дүнгийн жагсаалт.